"Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн
Салбарын захирлын 2019 оны
01 дугаар сарын 31-ны өдрийн
A/05 дугаар тушаалын хоравдугаар
хавсралт

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЦОГТЦЭЦИЙ СУМ
ДАХЬ САЛБАР
1115215676
135528 • СБА1329
ӨМНӨГОВЬ АЙМАГ

# УУРХАЙН АВТОМАШИН, ТЕХНИКҮҮДЭД ПАРКЫН ДУГААРЛАЛТ, ХАЯГЖУУЛАЛТ ХИЙХ ЗААВАР

## Нэг. Зорилго, хамрах хүрээ.

1.1. Энэхүү зааврын зорилго нь уурхайн автомашин, техникүүдийг паркын дугаараар нь ялган таних, нэгдсэн хаягжуулалттай болоход оршино.

1.2. Энэ зааврыг "Эрдэнэс-Тавантолгой" ХК (цаашид "ЭТТ" ХК гэх)-ийн нийт ажилтан болон гэрээт компанийн ажилтнууд нэгэн адил дагаж мөрдөнө.

## Хоёр. Ерөнхий шаардлага.

Уурхайн бүсэд ажиллаж байгаа техник тоног төхөөрөмжийн парк дугаар нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1. Тухайн техникийг ямар нэгэн эргэлзээ төрүүлэлгүй ялган таних боломжтой байх;
2.2. Зайнаас буюу хамгийн багадаа 50м-ээс өдөр шөнийн алинд ч тод, гаргацтай харагдахуйц байх;
2.3. Бүх талаас харагдах боломжтой байх;
2.4. Оператор хялбар арчиж цэвэрлэх боломжтой байрлалд байх;
2.5. Давхцахгүй, андуурах боломж үүсгэхгүй байх;
2.6. Амархан тоос, шороонд бохирдож дарагддаггүй хэсэгт байрлуулах;
2.7. Жигд, нэг стандартын байх зэрэг юм.

## Гурав. Автомашины паркын дугаарлалт.

<table>
<tr><th rowspan="2">№</th><th colspan="4">Паркын дугаар хийх загварын томъёолол</th></tr>
<tr><th>Овор хэмжээ, зориулалт</th><th>Код</th><th>Дугаар</th><th>Жишээ:</th></tr>
<tr><td>1</td><td>Бага оврын суудлын машин</td><td>LV</td><td>***</td><td>LV 001-099 ЭТТ,<br>LV 100-199 Зүүн уурхайн гэрээт<br>LV 200-299 Баруун уурхайн гэрээт</td></tr>
<tr><td>2</td><td>Үйлчилгээний машин</td><td>SV</td><td>***</td><td>SV 001-099 ЭТТ,<br>SV 100-199 Зүүн уурхайн гэрээт<br>SV 200-299 Баруун уурхайн гэрээт</td></tr>
<tr><td colspan="5"></td></tr>
<tr><td colspan="5">Паркын дугаар нь машины 2 талд хаалган дээр, мөн урд талд болон ард талд байрлуулна.</td></tr>
<tr><td colspan="5">Хар дэвсгэр дээр шар өнгөөр "ARIAL" фонтоор "BOLD"-оор хэмжээтэй бичсэн байна. Хар өнгөний код 250, шар өнгөний код 503.</td></tr>
<tr><td colspan="5">Үсгийн өндөр нь 160 x 540 мм хэмжээтэй байхаар үсгийг шахаж байрлуулсан байна.</td></tr>
<tr><td colspan="5">Хажуу болон урд талын дугаарын дэвсгэр нь 220 x 600 мм хэмжээтэй байна. /Зураг №1а, 1б-д үзүүлэв./</td></tr>
<tr><td colspan="5">Ард талын дугаарын дэвсгэр нь 160 x 580 мм хэмжээтэй байх ба автомашины арын дээд хэсэгт ачааны дээр эсвэл тусгай төмөр суурин дээр тогтооно. /Зурагт №2а, 2б-д үзүүлэв/</td></tr>
</table>



ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ ДАХЬ САЛБАР
№ 01




Зураг №1.а
/Автомашины хажуу тал болон урд талд байрлуулах дугаарлалтын хэмжээ/




Зураг №1.б
/Автомашины хажуу тал болон урд талд байрлуулсан байдал/




Зураг №2.а
/Автоамашины ард талд байрлуулах дугаарлалтын хэмжээ/




Зураг №2.б
/Автоамашины ард талд байрлуулсан байдал/

**Дөрөв. Техникүүдийн паркын дугаарлалт.**

ЭТТ ХК-ийн уурхайд мөрдөх техникийн парк дугаар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.1. *Усэг, тооны загвар:* **Arial** фонтоор **Bold**-оор бичсэн байна.

**1234567890**

4.2. *Өнгө:* Хар дэвсгэр дээр тод шар өнгөөр байна. Шар өнгө нь цацруулагчтай буюу гэрэл ойлгодог эсхүл гэрэлтдэг байна.

4.3. *Хэмжээ:* Тооны өндрөөр 4 стандарт байна:

| № | Стандарт | Тооны өндөр |
|---|---|---|
| 1 | **I** - стандарт | 300мм |
| 2 | **II** - стандарт | 420мм |
| 3 | **III** - стандарт | 600мм |
| 4 | **IV** - стандарт | 800мм |

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн
ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ
ДАХЬ САЛБАР
№ 01

4.4. Техникт дугаарлалт хийхдээ дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

4.4.1. Автосамосвалуудад зөвхөн тоогоор дугаарлалт хийнэ.

4.4.2. Грейдер болон бульдозер, дугуйт ачигч, тэдгээртэй адилтгах 4м-ээс доош өндөртэй техникүүдэд парк дугаарыг гурван талт суурин дээр хийж кабины орой дээр байрлуулах бөгөөд дээр нь маяк суурилуулна.

4.4.3. Экскаваторын парк дугаарыг их биенээс гадна үндсэн сумны 2 талд байрлуулна.

4.4.4. Дугаарлалтын тоог давхцуулахгүйгээр 2-3 оронтой тоогоор сонгож өгнө.

**МТ маркын автосамосвалтай адил овор хэмжээтэй автосамосвалд:**




Зураг №3. Урд талд нүүрэн дээр 4-р стандартаар хийнэ.







Зураг №4, 5. Дээрээс болон шатанд зүүх 2 байрлал байна. 3-р стандартаар хийнэ.

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн
ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ
ДАХЬ САЛБАР
№ 01

**CAT773 маркын автосамосвалтай адил даац, хэмжээ бүхий автосамосвалд:**




Зураг №6. Арын дугаарыг 2-р стандартаар хийж резин эсхүл метал суурин дээр байрлуулна.




Зураг №7. Урд болон хажуугийн дугаарыг 3-р стандартаар хийж МТ4400-ийн адил байрлуулна.




Зураг №8. Грейдер болон дугуйт ачигчийн орой дээр хийсэн 3-н талт номерыг харуулав.

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ ДАХЬ САЛБАР
№ 01

Энэ суурь нь хамгийн багадаа 1-р стандартаар бичигдсэн байна. Мөн хар дэвсгэр дээр тод шар өнгийн гэрэлтдэг эсхүл гэрэл ойлгогчоор бичигдсэн байна. Энэхүү 3-н талт суурь бага зэрэг (20ºC орчим)-ийн налуутай байж болно.

Доорх зургуудад техникт тууз наах болон дугаар байрлуулах боломжуудыг харуулав.










ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн
ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ
ДАХЬ САЛБАР
№ 01

## Тав. Уурхайд ашиглаж байгаа автосамосвалуудын тэвшний урд хөмсгөн дээр байрлуулах хуулганы хэмжээ, загвар.

MT4400




Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 8м**X**0.6м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,8м**X**0,4м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

Тухайн техникийг эзэмшигч гэрээт компанийн лого байна.

MT4400




Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 8м**X**0.6м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,8м**X**0,4м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

MT3300




Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 6,5м**X**0,6м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,8м**X**0,4м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

CAT785




Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 6,6м**X**0,35м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,6м**X**0,3м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

CAT777




Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 6,1м**X**0,35м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,6м**X**0,3м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

CAT773




CAT773







Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 4м**X**0,22м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,4м**X**0,2м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

TR60
TR100




Суурийн дэвсгэр өнгө шар, суурийн хэмжээ 5.2м**X**0,14м
ЕТТ компанийн логоны хэмжээ 0,12м**X**0,6м
Гэрээт компанийн логоны өргөн ЕТТ логоны өргөний 2**x**1 байна.

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ ДАХЬ САЛБАР
№ 01




"**АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**" гэсэн үгийн оронд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллахтай холбогдолтой уриа, сэрэмжлүүлэг байж болно.

**Зургаа. Хариуцлага.**

6.1 Энэхүү журмыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд "ЭТТ" ХК-ийн холбогдох журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2 Гэрээт компанийн ажилтан энэ зааврыг зөрчсөн тохиолдолд зөрчлөөр бүртгэж, хариуцлагын арга хэмжээ авах үндэслэл болно.

БАТАЛСАН:
САЛБАРЫН ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭХУЯГ

ХЯНАСАН:
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР Т.НЯМ-ОСОР

ХАБЭА-Н ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ Б.БАТ-ОРШИХ

БАТСУУРЬ
БАТ-ОРШИХ
ТТТ6594 ... ЕС89081832

БОЛОВСРУУЛСАН:
ХАБ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭНГЭЛЖАРГАЛ

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-ийн
ӨМНӨГОВЬ АЙМАГ ЦОГТЦЭЦИЙ СУМ
ДАХЬ САЛБАР
№ 01